

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 02 дугаар
сарын 15-ны өдөр

№ 04

Улаанбаатар хот

ХААН Банк ХК, Монгол Улсын нээлттэй хувьцаат компани (регистрийн дугаар 2693321, улсын бүртгэлийн дугаар 9007001013) (цаашид “Банк” гэх)-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд дараах тогтоолыг үүгээр батлав. Үүнд:

ҮНДЭСЛЭЛ: Монгол Улсын Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1-т Компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол Төлөөлөн удирдах зөвлөл ногдол ашиг хуваарилах эсэх тухай шийдвэрийг гаргах бөгөөд уг шийдвэрт хувьцаа бүрд ногдох ашгийн хэмжээ, ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах өдөр болон ногдол ашиг төлөх өдөр зэргийг заах болохыг;

ҮНДЭСЛЭЛ: Монгол Улсын Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.5-д Төлөөлөн удирдах зөвлөл нь санхүүгийн жил дууссанаас хойш 50 хоногийн дотор ногдол ашиг хуваарилах эсэх талаар хэлэлцэн шийдвэрлэсэн байхаар заасныг;

ҮНДЭСЛЭЛ: Банкны Дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.13.14-т Банкны Төлөөлөн удирдах зөвлөл нь Банкны дүрэмд өөрөөр заагаагүй бол ногдол ашиг хуваарилах эсэх шийдвэр гаргах, ногдол ашгийн хэмжээ, түүнийг төлөх журмыг тодорхойлохоор заасныг;

ҮНДЭСЛЭЛ: Банкны ТУЗ-ийн 2023 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн 26 тоот тогтоолын хавсралт №1-ийн дагуу баталсан “ХААН Банк ХК-ийн Ногдол ашгийн бодлого”-д заасныг

ТУС ТУС ҮНДЭСЛЭН, ийнхүү:

- ТОГТООХ НЬ:** Банкны 2023 оны санхүүгийн гүйцэтгэлд тулгуурлан татварын дараах цэвэр ашиг болох 558,782,869,011 (*таван зуун тавин найман тэрбум долоон зуун наян хоёр сая найман зуун жаран есөн мянга арван нэг*) төгрөгийн 48.5 хувь буюу 271,015,822,540 (*хоёр зуун далан нэгэн тэрбум арван таван сая найман зуун хорин хоёр мянга таван зуун дөчин*) төгрөгийг нэгж хувьцаанд 141.73 (*нэг зуун дөчин нэгэн төгрөг далан гурван мөнгө*) төгрөгөөр тооцож, ногдол ашгийг мөнгөн хэлбэрээр хуваарилахыг зөвшөөрсүгэй.
- ТОГТООХ НЬ:** Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2024 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бүртгэлийн өдрөөр тасалбар болгон тогтоосугай.
- ТОГТООХ НЬ:** Ногдол ашиг хуваарилахтай холбоотой эрх бүхий зохицуулагч байгууллагын зохих зөвшөөрлийг хүлээн авснаас хойш ажлын 5 өдрийн дотор “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-иар дамжуулан ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн дансанд байршуулан тараасугай.

4. **ТОГТООХ НЬ:** ТУЗ-ийн дарга хатагтай Т.Дарьбум, Гүйцэтгэх захирал хатагтай Р.Мөнхтуяа нарт энэхүү тогтоолыг хэрэгжүүлэх, биелэлтэд хяналт тавихтай холбоотойгоор өөрийн бүрэн эрхийн хүрээнд авах шаардлагатай гэж үзсэн бүхий л арга хэмжээг авах эрхийг олгосугай.

БАТЛАВ



Д.Хулан

Харада Ясүнари

Ц.Баатарсайхан

Кисабүро Иший

Жон Ло

А.Тамир

Аарт Йонгеянс

Б.Амарсанаа

4. **ТОГТООХ НЬ:** ТУЗ-ийн дарга хатагтай Т.Дарьбум, Гүйцэтгэх захирал хатагтай Р.Мөнхтуяа нарт энэхүү тогтоолыг хэрэгжүүлэх, биелэлтэд хяналт тавихтай холбоотойгоор өөрийн бүрэн эрхийн хүрээнд авах шаардлагатай гэж үзсэн бүхий л арга хэмжээг авах эрхийг олгосугай.

БАТЛАВ

Т.Дарьбум

Д.Хулан

Харада Ясүнари

Ц.Баатарсайхан

Кисабүро Иший

Жон Ло

А.Тамир

Аарт Йонгеянс

Б.Амарсанаа



4. **ТОГТООХ НЬ:** ТУЗ-ийн дарга хатагтай Т.Дарьбум, Гүйцэтгэх захирал хатагтай Р.Мөнхтуяа нарт энэхүү тогтоолыг хэрэгжүүлэх, биелэлтэд хяналт тавихтай холбоотойгоор өөрийн бүрэн эрхийн хүрээнд авах шаардлагатай гэж үзсэн бүхий л арга хэмжээг авах эрхийг олгосугай.

БАТЛАВ

Т.Дарьбум



Д.Хулан

Харала Ясүнари

Ц.Баатарсайхан

Кисабүро Иший

Жон Ло

А.Тамир

Аарт Йонгеянс

Б.Амарсанаа

4. **ТОГТООХ НЬ:** ТУЗ-ийн дарга хатагтай Т.Дарьбум, Гүйцэтгэх захирал хатагтай Р.Мөнхтуяа нарт энэхүү тогтоолыг хэрэгжүүлэх, биелэлтэд хяналт тавихтай холбоотойгоор өөрийн бүрэн эрхийн хүрээнд авах шаардлагатай гэж үзсэн бүхий л арга хэмжээг авах эрхийг олгосугай.

БАТЛАВ

Т.Дарьбум

Д.Хулан

Харада Ясүнари

Ц.Баатарсайхан

Кисабүро Иший

Жон Ло

А.Тамир

Аарт Йонгяанс

Б.Амарсанаа



4. **ТОГТООХ НЬ:** ТУЗ-ийн дарга хатагтай Т.Дарьбум, Гүйцэтгэх захирал хатагтай Р.Мөнхтуяа нарт энэхүү тогтоолыг хэрэгжүүлэх, биелэлтэд хяналт тавихтай холбоотойгоор өөрийн бүрэн эрхийн хүрээнд авах шаардлагатай гэж үзсэн бүхий л арга хэмжээг авах эрхийг олгосугай.

БАТЛАВ

Т.Дарьбум

Д.Хулан

Харада Ясүнари

Ц.Баатарсайхан

Кисабүро Иший

Жон Ло



А.Тамир

Дарт Йонгяанс

Б.Амарсанаа